

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2022 оны 09 дүгээр сарын мэдээ

2022.09.26

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: ИТХ-ын ээлжит бус хуралдааныг 9 дүгээр сарын 8 өдөр хуралдаж дараахь асуудлыг хэлэлцэн баталлаа.

1. Сумын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай

2. Сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл хэлэлцэх тухай.

3 Сумын газар зүйн нэрийн мэдээллийн сангийн нэрсийн жагсаалтыг батлах тухай.

4. Сумын 2022 оны төсвийн нэр төрлийг өөрчлөх тухай

5. Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах эргэн төлүүлэх хяналт шалгалт тавих журмыг хэлэлцэх зөвлөл байгуулах тухай.

6. Бусад асуудал

Монгол Улсад төрийн хэлмэгдүүлэлтийн өдөрт зориулж ЕБС-ийн 9- 12 дугаар ангийн сурагчдын дунд Монгол улсад төрийн хэлмэгдүүлэлт, дүгнэлт, сургамж сэдэвт хичээлийг ЕБСургуулийн түүх, нийгэмийн ухааны багш нартай хамтран зохион байгуулж холбогдох тайланг аймгийн ИТХ-ын ажлын албанд хүргүүллээ.

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Тухайн сард дээд газраас 12 албан бичиг ирсний 6 нь хариутай, 2—нь хугацаандаа, 4—нь хугацаа болоогүй байна.

“Үндэсний үйлдвэрлэл –Эрүүл хүнс 2022” арга хэмжээний хүрээнд жил бүр уламжлал болгон явуулдаг “Намрын ногоон өдрүүд – Баяндэлгэр 2022” үзэсгэлэн худалдааг 2022 оны 09 дүгээр сарын 19 -нд амжилттай зохион байгууллаа.

Аймгийн засаг дарга М.Идэрбатаар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 09 дүгээр сарын 22-ны өдөр тус суманд ажиллаж төсвийн байгууллагын ажил байдал, орон нутгийн өвөлжилтийн бэлтгэл, цаг үеийн байдалтай танилцаж, албан байгууллагуудад тулгамдсан асуудлыг сонсож шийдвэрлэн иргэд хөдөлмөрчидтэй уулзалт зохион байгууллаа.

Хоёр: Төсөв санхүүгийн чиглэлээр: - 2022 оны орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээлээ.

- Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэг, тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилтыг хуваарийн дагуу эхний 9 сар бүрэн олгогдсон.

- Байгууллагын өр авлага ,төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч ЗГУСХС бүрэн мэдээлсэн .

- Статистикийн байгууллагад хүргүүлэх сар улирлын мэдээ тайланг хугацаанд нь гаргаж явуулсан.

-Төсөвт байгууллагуудын цалин болон бусад гүйлгээг төлбөрийн хүсэлтийн дагуу цаг хугацаанд нь санхүүгийн программд шивж гүйцэтгэн төлбөрийн хүсэлт болон баримтыг хуулгатай тулган архивын нэгж үүсгэн ажиллаа.

-Төсөвт байгууллага, татварын орлогын дансанд гарын үсгийн баталгааг авч нотариатоор баталгааж, цахим мэдээллийн системд оруулж ажиллаа.

ОНХСан, малын тоо толгойн албан татвараар хийгдэх ажил болон засаг даргын мөрийн хөтөлбөрөөр хийгдсэн ажлуудын санхүүжилт хуваарын дагуу олгогдож цаг хугацаандаа хийгдсэн.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: Хөдөөгийн багийн иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулж цаг үеийн асуудал, өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар мэдээлэл өгч ажиллаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Ерөнхий боловсролын сургууль: 08 дугаар сарын 26-ны өдөр 3 сургалтын менежер, ЗАН-н ахлагч нар Сүхбаатар аймагт сургалтад хамрагдлаа. Хичээлийн шинэ жилийн нээлт 09 дүгээр сарын 01-ны өдөр шинэ залуу боловсон хүчин болон нийт багш нартай уулзаж ажлын чиглэл зөвлөмжийг хүргэлээ.

09 дүгээр сарын 09-ны өдөр сумын ЗДТГ-ын удирдлагууд 9-12 дугаар ангийн сурагчидтай уулзалт зохион байгууллаа.

1-р ангийн хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх судалгааны ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. 12-16-ны өдрүүдэд 6-12 дугаар ангийн англи хэл, монгол хэлний хичээлээр гарааны үнэлгээний шалгалт явагдлаа.

16- 18-ны өдрүүдэд сургуулийн номын санч Сүхбаатар аймагт “Үндэсний бичиг соёл номын өдрүүд-2022” арга хэмжээнд оролцлоо.

21- 26-ны өдрүүдэд “Хувь хүний ур чадвар энтрепернершил боловсрол” олгох төслийн сургагч багш нар цахим сургалтад хамрагдлаа.

09 сарын 22-ны өдөр БСУГ-ын мэргэжилтэн нар болон Аймгийн засаг дарга, агентлагын дарга нар сургуулийн өвөлжилтийн бэлтгэл байдал, тулгамдаж буй асуудлын талаар сонсож уулзалт зохион байгуулсан. БСУГ-ын мэргэжилтэн нар багш бүрийн хичээлд сууж зөвлөн туслалаа.

09 сарын 23, 24-нд сурагчдын –“Намрын спартакиад” болж өнгөрлөө.

Соёл: 09-01нд Хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагааг ЕБС, СӨБ-ын Бөмбүүлэй цэцэрлэгтэй хамтран зохион байгууллаа.

09.12-нд Соёлын ажилтаны өдөр, Үндэсний бичиг үсэг номын баярын өдрийг тохиолдуулан “Соёлын орон зай” өдөрлөгийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Өдөрлөгийн нээлтийн ажиллагаа, Шинэ номын үзэсгэлэн, бүжгийн дугуйлангийн сурагчдын үзүүлэх тоглолт, бүжгийн дугуйлан, дууны дугуйлангийн хичээлийн шинэ жилийн нэмэлт элсэлтийн бүртгэл хөтөлбөрт үдшийн цэнгүүн зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа.

Соёлын төвийн номын сан нь ажлын 8 цагаар тогтмол ажиллаж уншигч үйлчлүүлэгчдэд гэрээр болон танхимаар ном олгож ажиллаа.

9-р сард байнгын уншигч 32, ирэгсэд 143 хүнд 187 ном гэрээр олгож 6 хүнд утсаар болон амаар лавлагаа өгч 5 татгалзал бүртгэлээ.

Баяндэлгэр Соёлын төв цахим группт уран зохиол-2022, соёлын өв-2022, судар эгшиглэн-2022, дотоод үйл ажиллагаа-2022 булангуудыг хөтлөн нийт 13 мэдээлэл орууллаа.

ТСҮХД-ын улсын тооллогоболохтой холбогдуулан сум орны хамгаалалтанд байдаг 192ш үл хөдлөх дурсгалын маршрутыг гаргаж тооллогын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Бүжгийн дугуйлангийн хичээлийн шинэ жилийн элсэлт явагдаж сурагчдаа бүртгэн хувиарийн дагуу 3 ээлжээр хичээллэж сургуулийн насны бага, дунд, ангийн сурагчдад ардын бүжгийн дасгал хөдөлгөөнүүдийг зааж сургаж байна.

Бүжгийн дугуйлангийн сургалтанд бага ангийн 78 дунд ангийн 38 нийт 116 сурагч хамрагдаж байна.

09.12-нд Соёлын ажилтаны өдөр, Үндэсний бичиг үсэг номын баярын өдрийг тохиолдуулан “Соёлын орон зай” өдөрлөгийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Өдөрлөгийн нээлтийн ажиллагаа, Шинэ номын үзэсгэлэн, бүжгийн дугуйлангийн сурагчдын үзүүлэх тоглолт, бүжгийн дугуйлан, дууны дугуйлангийн хичээлийн шинэ жилийн нэмэлт элсэлтийн бүртгэл хөтөлбөрт үдшийн цэнгүүн зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа.

Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор Үдшийн цэнгүүн 3 удаа зохион байгууллаа.

09.17-нд Соёлын яамны дэмжлэгтэйгээр хийгдэж буй Дэлхийн соёлын фестивалд оролцох “ХАРАХ ОРОН ЗАЙ” баримтат киноны зураг авалтанд соёлын биет бус өв тээгчдийг хамруулан оролцож хувцас жижиг хэрэгсэл, техник хэрэгсэл болон бусад туслалцаа үзүүлж хамтран ажиллаа.

Сумын засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулаган ТСҮХД-ын улсын тооллогын бэлтгэл ажиллагааг ханган ажиллаж байна.

Цэцэрлэг: 2022-2023 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлыг ханган гадна дотно орчны урсгал засварыг хийж, дотор талын 7 бүлгийг хивсээр, 9 бүлгийг тоос сорогч, бүлгийн багш, даргын өрөө, эмч, аргазүйч нарын сандлыг шинэчилсэн. Гадна талбайдаа хүүхдэд тоглох шинэ тоглоом, гэрэлтүүлэгийг нэмсэн.

9 бүлэгт өдрөөр 257 хүүхэд, хувилбарт сургалтандаа 178 хүүхдийг тус тус хамруулан ажиллаж байна.

Шинэ цэцэрлэгийн барилгыг хянан шалгахаар аймгийн барилга хот байгуулалт тохижуулалтын газар, БШУГ-ын дарга нарын бүрэлдэхүүнтэй баг ирж ажлын явцтай танилцан хариу арга хэмжээг авсан.

БШУГ-ын зөвлөн туслах баг хамт олон манай байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа болон сургалтын үйл явц, багш нарын хөтлөдөг бичиг баримтыг шалгаж аргазүйн зөвөлөгөөг өгч ажиллаа. Манай байгууллага нь өнгө үзэмжээ нэмсэн ахиц дэвшилттэй сайн ажиллаж байна гэсэн үнэлгээгээр дүгнэсэн.

Эрүүл мэндийн төв: Нийт үзлэгт-315 урьдчилан сэргийлэх үзлэг – 60 Амбулатори-206 байна.

Больницод 24 иргэн хэвтэн эмчлүүлсэн ба алсын дуудлагад –19 удаа аймгийн нэгдсэн эмнэлэгт 7 удаа өвчтөн тээвэрлэсэн байна. ирсэн дуудлага бүрийг хугацаа алдалгүй шийдвэрлэсэн.

Жирэмсний хяналтанд нийт-12, АНЭ-т тухайн сард 7 эх амаржсан. Эх хүүхдийн эргэлт – 13, Эсийн шинжилгээ – 29, Хөхний үзлэгт – 51 хамрагдсан.

СЗЭ-ний кабинетаар нийт давхардсан тоогоор 54 хүнд 5 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлсэн.

Сериологи - 15

В С вирус -15

Үе мөч-10

Больницийн их засвар хийгдэж байна /207 сая төгрөг, /АЗД-ын санхүүжилтээр/

Орон нутгийн төсвөөр АНЭ-ийн нарийн мэргэжлийн эмч нар ирж иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийв. 5 төрлийн үзлэг зохион байгуулж нийт 1300 хүн хамруулав.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчин: Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, аймгийн төвд зөөвөрлөх ажлын хүрээнд сумын ЗДТГ-6, худалдаа үйлчилгээ эрхлэгч байгууллага 15 ширхэг хог хаягдлыг ангилагч зориулалтын хогийн савыг худалдан аваад байна.

Анхан шатанд нь ахуйн хог хаягдлыг ангилан ялгасан, бусдад үлгэр дуурайлал үзүүлсэн айл өрх, аж ахуй нэгж байгууллагуудыг урамшуулах, олон нийтэд сурталчлах, нүхэн жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах эко жорлон бариулах санал санаачилгыг дэмжин ажиллах зорилгоор сумын Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 18 ны өдрийн А/74 дүгээр захирамжаар “Хашаандаа сайхан амьдаръя” болзолт уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд 05 дугаар сараас 09 дүгээр сарыг хүртэлх хугацаанд явагдаж 13 өрх оролцлоо. Уралдааны шалгаруулалтыг 10 дугаар сарын эхний долоо хоногт явуулж, удирдамжийн дагуу дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлхээр бэлтгээд байна. Сумын хэмжээнд бохирын автомашин шинээр үйл ажиллагаанд орсонтой холбоотойгоор тухайн жилд 52 ширхэг эко нойл суурилуулагдаж, ашиглалтад ороод байна.

Цэцэрлэгт хүрээлэнгийн талбайн хашаанд 2, нэгдсэн хогийн цэгийн талбайд 2 нэг бүрийн үнэ 550 000 төгрөгийн үнэ бүхий 4 камерыг суурилууллаа.

Хөдөө аж ахуй: “Үндэсний үйлдвэрлэл –Эрүүл хүнс 2022” арга хэмжээний хүрээнд жил бүр уламжлал болгон явуулдаг “Намрын ногоон өдрүүд – Баяндэлгэр 2022” үзэсгэлэн худалдааг 2022 оны 09 дүгээр сарын 19 нд амжилттай зохион байгууллаа. Малчид, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үйлчилгээ, мэдээллийг олон нийтэд сурталчилан танилцуулах, үйл ажиллагааг нь дэмжин хөгжүүлэх, харилцан туршлага солилцуулах, сумын шилдэг бүтээгдэхүүнийг бий болгох зорилгоор сумын Засаг даргын нөөц сангаас 1000,0 сая төгрөгийн санхүүжилтийг гаргаж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сүү, сүүн бүтээгдэхүүн, гурилан бүтээгдэхүүн, оёмол бүтээгдэхүүн, хүнсний ногоо, төмөр, модон эдлэл, малын гаралтай түүхий эдээр хийсэн бүтээгдэхүүн , сумын шилдэг бүтээгдэхүүн гэсэн 7 төрлөөр шалгаруулан, шагнаж урамшуулсан.

Сумын шилдгээр шалгарсан үйлдвэрлэл эрхлэгчид “Намрын ногоон өдрүүд Сүхбаатарт үйлдвэрлэв 2022” үзэсгэлэн худалдаанд 2022 оны 09 дүгээр сарын 28-29 ны өдрүүдэд оролцохоор бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.

Сумын аюулгүй нөөцийг бүрдүүлэх зорилгоор 2000 боодол өвсийг Эрдэнэцагаан сумаас татаж нөөцлөөд байна.